

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/9/СТА-ТӨҮГ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2-3
2. Аудитын тайлан	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагааны, хууль, эрх зүйн орчин	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	7
2.8.1.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11 Шилэн дансны мэдээлэл	8
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал	10
3.1 Худалдан авалттай холбоотой асуудал.....	10
3.1.1 Илрүүлэлт:	10
3.1.2 Эрсдэл:	10
3.1.3 Өгсөн зөвлөмж:	10
3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудитын хийсэн санхүүгийн байдлын тайлан:	11-12
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан:	13
4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан:.....	14
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан:	15-16
4.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл	17
4.6 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ”
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.МИНЖИНХҮҮ ТАНАА

2019.03.20 № 06/512
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Минжинхүү Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 15-наас 2019 оны 3 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Лидер экаунт аудит” ХХК-ийн аудитор П.Шаравхорол, ахлах аудитор Д.Лхамсүрэн, аудиторын туслах О.Мөнхтуяа нар хэрэгжүүлэв.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг “Лидер экаунт аудит” ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 76 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Налайхын дулааны станц” ТӨХК нь хэрэглэгчээ дээдлэн, дэвшилтэт технологид түшиглэсэн дулааны эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэл явуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Тус компани нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2009 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор олгосон дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд Налайх дүүргийн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон 2281 айл өрх, 29 төсвийн байгууллага, 261 аж ахуйн нэгж байгууллагыг дулааны эрчим хүчээр ханган ажиллаж байна.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус компанийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Энэ нь нийт болон цэвэр хөрөнгөөс материаллаг байдлын түвшинг тогтооход материаллаг түвшин өндөр гарч байгаа тул байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгосонтой холбоотой юм.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны нийт зардал 4,532.7 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 45.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь аудитын үед голчлон хөрөнгийн зарцуулалтыг авч үздэгтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.1 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	39.5	
2	Албан шаардлага өгсөн	1	3.5	
Дүн		2	43.0	

2.8.1.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Өглөгийн талаар

Хоёр аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 3.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг баримтлан хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дулаан үйлдвэрлэлийн өртөг зардлыг үнэн зөв, бодитой тогтоох, нүүрс зарцуулалтын норм нормативыг тогтоохтой холбогдон станцад түлж байгаа нүүрсний зарцуулалтыг тооцох хэмжүүртэй болох, шаардлагатай байна. Хөрөнгийн дахин үнэлгээг мэргэшсэн үнэлгээчин Ганхуягаар хийлгэж, санхүүгийн тайлагналын бодит үнэ цэнийг 9,720.8 сая төгрөг гэж тооцоолж, компанийн газар эзэмших эрх, барилга, байгууламжийн нийт хөрөнгийг үнэлж, дүгнэлт өгсөн байна.

2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 онд зорилтот түвшний төлөвлөгөөнд борлуулалтын орлого 3,586.1 сая төгрөг байхаар батлагджээ. Гүйцэтгэлээр борлуулалтын орлого 3,769.2 сая төгрөг болж, орлогын төлөвлөгөөг 5.1 хувиар буюу 183.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2018 оны зорилтот түвшний төлөвлөгөөнд нийт зардлыг 5,509.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 4,532.7 сая төгрөг болж, зардлыг 976.7 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулж, 2018 онд 448.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

“Налайхын дулааны станц” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Налайхын дулааны станц” ТӨХК Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn/Налайхын дулааны станц ТӨХК цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн талаар 220, хөрөнгийн урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн талаар 112, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн талаар 192, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9

дүгээр зүйлд заасан мэдэгдлийн талаарх мэдээллийг боловсруулан хуулийн хугацаанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 80 хувьтай байна.

Өмнөх зөвлөмжөөр өгсөн он дамжсан найдваргүй авлага, 19.1 сая төгрөгийг хуулийн байгууллагад шилжүүлсэн боловч энэ нь бүрэн хэрэгжээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 “Худалдан авахтай холбоотой асуудал”

3.1.1 Илрүүлэлт:

Тус компани нь тендер шалгаруулалтаар 39.5 сая төгрөгийн трубог гэрээний дагуу худалдан авсан ч гэрээг дүгнэж, хүлээн авсан акт үйлдээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Дээрхи нөхцөл байдал нь оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал зэрэг аудитын батламж, мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хийсэн гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах, гэрээ дүгнэсэн актыг үнэн зөв үйлдэж, үүргийн биелэлтийг дүгнэсний үндсэн дээр төлбөр тооцоог хийх талаар анхаарч ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	80,881,732.63	204,845,539.80
1.1.2	Дансны авлага	406,560,961.20	377,865,724.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	250,749,668.98	129,300,057.40
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	883,560.00	
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	739,075,922.81	712,011,321.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,360,858,458.86	7,866,834,300.33
1.2.2	Биет бус хөрөнгө	42,711,250.00	1,853,990,250.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,403,569,708.86	9,720,824,550.33
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,142,645,631.67	10,432,835,871.53
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,756,900,880.80	1,140,892,808.39
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	156,396,898.35	86,091,293.93
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		

2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3,940,120.09	2,235,423.81
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,917,237,899.24	1,229,219,526.13
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,917,237,899.24	1,229,219,526.13
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	3,392,872,148.47	6,373,866,456.47
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	531,843,250.00	2,727,654,260.64
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,980,994,308.00	1,820,434,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,680,301,974.04)	(1,718,338,371.71)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,225,407,732.43	9,203,616,345.40
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,142,645,631.67	10,432,835,871.53

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,907,309,605.08	3,657,579,108.54
2	Борлуулалтын өртөг	4,153,698,850.84	4,310,977,159.08
3	Нийт ашиг (алдагдал)	(1,246,389,245.76)	(653,398,050.54)
4	Түрээсийн орлого	2,696,045.46	3,698,181.83
5	Хүүгийн орлого	6,553,016.12	10,398,634.09
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	54,940,282.28	97,521,212.36
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	100,632,974.44	120,512,494.54
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	1,272,727,272.74	1,171,504,107.94
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(10,105,603.60)	509,211,591.14
19	Орлогын татварын зардал		61,025,088.81
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(10,105,603.60)	448,186,502.33
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(10,105,603.60)	448,186,502.33
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,392,872,148.47			531,843,250.00			(2,670,196,370.44)	1,254,519,028.03
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл	3,392,872,148.47			531,843,250.00			(2,670,196,370.44)	1,254,519,028.03
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(10,105,603.60)	(10,105,603.60)
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт						2,980,994,308.00		2,980,994,308.00
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	3,392,872,148.47			531,843,250.00		2,980,994,308.00	(2,680,301,974.04)	4,225,407,732.43
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							513,777,100.00	513,777,100.00
11	Залруулсан үлдэгдэл								
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							448,186,502.33	448,186,502.33
13	Бусад дэлгэрэнгүй орлого								
14	Өмчид гарсан өөрчлөлт	2,980,994,308.00					(2,980,994,308.00)		
15	Зарласан ногдол ашиг								
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				2,195,811,010.64		1,820,434,000.00		4,016,245,010.64
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	6,373,866,456.47			2,727,654,260.64		1,820,434,000.00	(1,718,338,371.71)	9,203,616,345.40

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,394,828,264.37	5,457,258,654.04
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,938,821,493.37	4,022,585,425.26
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		331,901.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	17,915,671.00	16,420,189.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	14,000,000.00	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,400,000,000.00	1,400,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	24,091,100.00	17,921,138.78
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,381,377,295.46	5,176,778,266.60
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,153,590,343.16	1,181,842,119.63
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	332,193,395.09	368,036,484.69
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	159,232,298.00	100,222,436.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	522,979,870.11	783,192,215.90
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,491,165,720.04	1,732,162,256.95
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	465,458,173.97	762,420,838.86
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,463,320.00	95,400.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	255,294,175.09	248,806,514.57
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,450,968.91	280,480,387.44
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,960,853.84	10,398,634.09
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	6,960,853.84	10,398,634.09
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,190,000.00	166,915,214.36
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		157,665,214.36
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		2,700,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	10,190,000.00	6,550,000.00
2.2.6			

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,229,146.16)	(156,516,580.27)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	10,221,822.75	123,963,807.17
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	70,659,909.88	80,881,732.63
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	80,881,732.63	204,845,539.80

4.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны мөн үе	2018 оны		Харьцуулалт	
				04 улирлын төлөвлөгөө	04 улирлын гүйцэтгэл	Өмнөх онтой	Төлөвлөгөөтэй
1	<u>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт</u>						
	а/ Гол нэр төрлөөр						
	Дулаан үйлдвэрлэлт	Биет	123.1	123.2	108.1	(15.0)	(15.1)
	б/Үнийн дүнгээр	мян.төг				0.0	0.0
2	Нийт орлого	мян.төг	2,971,499.0	3,586,129.9	3,769,197.1	797,698.0	183,067.2
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	2,907,309.7	3,536,129.9	3,657,579.1	750,269.5	121,449.2
	Хүүний орлого	мян.төг	5,199.6	2,500.0	10,398.6	5,199.0	7,898.6
	Бусад орлого /Маягт, тендер техникийн нөхцөл, үнсний, алданги торгуулийн, угаалгын, засвар үйлчилгээний орлогууд/	мян.төг	58,989.9	47,500.0	101,219.4	42,229.5	53,719.4
3	Нийт зардал	мян.төг	4,254,331.8	5,509,446.6	4,593,712.8	278,381.0	(976,733.8)
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	100,633.0	111,569.0	120,512.5	19,879.5	8,943.5
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	(1,282,832.7)	(1,923,316.7)	824,540.8	458,291.9	1,098,775.9
	Улсын төсвийн татаас	мян.төг	1,272,727.3	1,272,727.3	1,272,727.3	0.0	0.0
5	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	(10,105.4)	(650,589.4)	448,186.5	458,291.9	1,098,775.9
6	<u>Төсвийн төлбөрт нийт дүн</u>	мян.төг				0.0	0.0
	а/ Орлогын татварт	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	0.0
	б/ НӨТ	мян.төг	420,065.4	363,613.0	601,174.5	181,109.1	237,561.5
	в/ НДШ	мян.төг	332,193.4	318,636.7	368,036.5	35,843.1	49,399.8
	г/ ХАОАТатвар	мян.төг	141,303.4	141,300.0	152,386.6	11,083.2	11,086.6
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	5,828.1	8,102.8	7,642.7	1,814.6	(460.1)
	е/ Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	311.5	419.4	459.5	148.0	40.1
	ж/ Бусад татвар /Газрын төлбөрт/	мян.төг	1,266.1	1,268.2	2,254.0	987.9	985.8
7	Төрийн өмчийн ногдол ашигт	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	0.0
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	114.0	114.0	114.0	0.0	0.0
9	Нийт цалингийн сан	мян.төг	1,435,876.7	1,473,521.0	1,483,699.8	47,823.1	10,178.8
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	1,046.6	1,077.1	1,084.6	35.0	7.4
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төг	33,770.4	43,492.9	40,618.2	6,847.8	(2,874.7)
12	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.5	1.6	1.2	(0.2)	(0.3)
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян.төг	43,159.4	213,762.0	196,636.8	153,477.4	(17,125.2)
14	Нийт авлага	мян.төг	406,560.9	380,000.0	377,865.7	(28,695.2)	(2,134.3)
	Үүнээс: Найдваргүй	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	0.0
15	Нийт өглөг	мян.төг	1,917,237.9	1,900,000.0	1,229,219.5	(688,018.4)	(670,780.5)
	Үүнээс: Богино хугацаат	мян.төг	1,917,237.9	1,900,000.0	1,229,219.5	(688,018.4)	(670,780.5)
	Урт хугацаат	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	0.0

4.6 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2018
он

Аудитын
нэр

Санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын
код:

САГ-2019/9/СТА-ТӨҮГ

Шалгагдсан байгууллагын нэр:

“Налайхын Дулааны станц” ТӨХК

Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5	9	10
1	Хоёр аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 3.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	3.5	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал	Ц.Минжинхүү
				ТСБХД, Ерөнхий нягтлан бодогч	Д.Бадамлянхуа
2	Тус компани нь тендер шалгаруулалтаар 39.5 сая төгрөгийн трубог гэрээний дагуу худалдан авсан ч гэрээг дүгнэж, хүлээн авсан акт үйлдээгүй байна.	39.5	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал	Ц.Минжинхүү
				ТСБХД, Ерөнхий нягтлан бодогч	Д.Бадамлянхуа
Дүн		43.0			

[illegible]